



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/315

Булган сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай**

Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны IX/19 дүгээр тогтоолоор баталсан "Булган сумын хөгжлийн шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэн М.Даваадорж (ГА66030791)-ийн Булган сум 6 дугаар баг Залуус 10 дугаар гудамж 1002 тоотод байршилтай 6308008205 нэгж талбар бүхий амины орон сууц зориулалтаар эзэмшиж буй 600 м2 газар, "Шим булаг" ХХК (РД:2106124)-ийн эзэмшиж буй Булган сум 6 дугаар баг Булган 5 дугаар гудамж 534 тоотод байршилтай 6308007952 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 260 м2 газар, Булган сум 3 дугаар баг Дунд агуйт 1 дүгээр гудамж 101 тоотод байршилтай 6308005263 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 518 м2 газар, Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 2 дугаар гудамж 202 тоотод байршилтай 6308003406 нэгж талбар бүхий зочид буудал зориулалтаар эзэмшиж буй 400 м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг тус тус 15 жилээр, Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 3 дугаар гудамж 307 тоотод байршилтай 6308003372 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 6848 м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 7 жилээр тус тус сунгасугай.

2.М.Даваадорж, "Шим булаг" ХХК-ийн захирал Д.Дуламбаяр нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн М.Даваадорж, "Шим булаг" ХХК (Д.Дуламбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010299